



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/147

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, 32.1.3. дахь заалт, Монгол улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 –ын /б/ заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилт, хаваржилт хүндэрч байгаа Манхан, Дуут, Зэрэг, Буянт, Ховд, Дарви сумдад Онцгой байдлын газраас 1250 уут 40 кг жинтэй хорголжин тэжээлийг хаваржилт, мал төллөлтийн хүндрэлийг даван туулахад зориулан олгосугай.

2.Дээрх тэжээлийн санхүүжилт болох 27.500.000 төгрөг / хорин долоон сая таван зуун мянган /-ийг Онцгой байдлын газрын 100900031005 дансанд 2018 оны өвс тэжээлийн санхүүжилтийн үлдэгдлээс гарган шийдвэрлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/ -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ

02 00721

Zax A/147 Ch

Аймгийн Засаг даргын 2019 оны  
03 дугаар сарын 11-ний өдрийн  
А/147 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРААС ХАВАРЖИЛТ  
ХҮНДЭРСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВСАН 40 КГ ЖИНТЭЙ  
ХОРГОЛЖИН ТЭЖЭЭЛИЙН ТООЦОО

Сум	Тэжээлийн тоо	Мөнгөн дүн 30хувийн хямдрал /15400/	Мөнгөн дүн 100хувийн /22000/
Манхан	250	3.850.000	5.500.000
Дуут	300	4.620.000	6.600.000
Дарви	250	3.850.000	5.500.000
Буянт	250	3.850.000	5.500.000
Зэрэг	100	1.540.000	2.200.000
Ховд	100	1.540.000	2.200.000
нийт	1250	19.250.000	27.500.000

-оОо-